

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

***Хуралдааны товч тэмдэглэл:*** 1-2

***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*** 3-14

---

*1.Иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар /Бэрхийн уурхайн нэр бүхий 112  
иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай/ 3-12*

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Өргөдлийн байнгын хорооны  
12 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Ж.Галбадрах, С.Ганбаатар, П.Мөнхтулга, Д.Рэгдэл;

Чөлөөтэй: Б.Батцэцэг, Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Х.Баттулга.

**Нэг.Иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар** /Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, мөн газрын ахлах шинжээч П.Хишигжаргал, Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Ууганбаатар, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, нэхэмжлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцав.

Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийг судалсан талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Д.Ганмаа болон уг өргөдлийг нэхэмжлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэл нар тус тус танилцуулав.

Өргөдөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа нар хариулж, тайлбар хийв.

Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийг судалсан талаарх ажлын хэсгээс гаргасан саналд үндэслэн Байнгын хорооноос уг асуудлыг түргэвчилж шийдэхэд анхаарах тухай Засгийн газарт албан бичиг явуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэх асуудал нь хүний хувийн мэдээлэлтэй холбоотой тул уг асуудлыг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хуралдаан хаалттай горимд шилжив.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Нээлттэй хуралдаан 42 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
13 цаг 57 минут.

### **ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**О.Номинчимэг:** Өргөдлийн байнгын хорооны хуралдаан эхлэхэд бэлэн боллоо. Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Одоогоор нийт ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Сүхбаатар Эрдэнэбат гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг ирээд байна. Өнөөдөр бол Далайн Батбаяр гишүүн гадаад томилолттой, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн гадаад томилолттой, Жанчивын Галбадрах гишүүн гадаад томилолттой, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн орон нутгийн томилолттой, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн орон нутгийн томилолттой, Дүгэрийн Рэгдэл гишүүн гадаад томилолттой, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн эмнэлгийн чөлөөтэй гэсэн албан ёсны ирц юутай байна, орсон байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр Өргөдлийн байнгын хороогоор 2 асуудал хэлэлцэнэ. Эхний асуудал иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар буюу Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэний өргөдлийн тухай хэлэлцэж, шийдвэрлэнэ. 2 дугаарт иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хэлэлцэх буюу Өргөдлийн байнгын хороонд ирсэн өргөдөл гомдлуудыг нэг бүрчлэн ажиллагаа хийж, хэлэлцэж шийдвэрлэсэн талаар Байнгын хороондоо хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байгаа эсэхийг тодруулъя. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн? Байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

### ***Нэг.Иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар /Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай/***

Эхний асуудал Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэний өргөдлийн тухай. Энэ өргөдлийг бол энэ 112 иргэнийг итгэмжилсэн төлөөлөгч болох Д.Алтангэрэлээс ирүүлсэн өргөдөл байгаа. Ингээд энэ Бэрхийн уурхайн нэр бүхий иргэдийн итгэмжилсэн төлөөлөгч Д.Алтангэрэлээс Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн

байнгын хороонд хандан ирүүлсэн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Монгол Улсын Засгийн газрын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, Бэрхийн уурхай нэр бүхий 112 иргэдэд нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг Засгийн газарт даалгасан боловч шүүхийн шийдвэр биелэгдэхгүй 2 жил гаруй хугацаа өнгөрч байгаа талаар өргөдлийг хэлэлцэж эхэлнэ.

Уг өргөдлийг Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр, Даваасамбуугийн Ганмаа нар судалсан. Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа таныг, Ажлын хэсгийнхээ өргөдлүүдийг бол 2 олонх болон цөөнхөөс бүрдсэн 2 гишүүн хамтарч шийдвэрлэж, холбогдох талуудтай уулзаж, тодруулж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ ажилласан саналаа танилцуулна уу хэмээн урьж байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүний микрофоныг.

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу бүгдээрээ. Бэрхийн уурхайчдад олгох нөхөн төлбөрийн талаар танилцуулгаа хийе. 1.Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөс Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдуулан Засгийн газар 1999 оны 5 сарын 74 дүгээр тогтоолын 3Г заалт болон 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг удаа дараалан хэрэгжүүлэхгүй байгаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, тус уурхай нь хувьчлагдахаас өмнөх үеийн буюу 2004 оны 5 дугаар сар хүртэлх төрийн мэдэлд байх үед нөхөн төлбөр авах ёстой байсан итгэмжлэлийн дагуу нэр бүхий уурхайчдад олгох 2 удаагийн нөхөн төлбөрийн хохирлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Монгол Улсын Засгийн газраас гаргуулж, барагдуулах тухай нэхэмжлэл гаргасны дагуу Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2002 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 04 04 тоот шийдвэрээр Бэрхийн уурхайд ажиллаж байсан нэр бүхий 112 иргэний нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, Бэрхийн уурхайд ажиллаж байсан нэр бүхий иргэдээс нөхөн төлбөр олгуулахаар гаргасан хүсэлтийг эцэслэн шийдвэрлээгүй Монгол Улсын Засгийн газрын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, Бэрхийн уурхайд ажиллаж байхдаа үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан иргэдэд нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан бөгөөд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 05 70 дугаар магадлалаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн боловч шүүхийн шийдвэр биелэгдэхгүйгээр 3 жил гаруй хугацаа өнгөрсөн байна.

Иймд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Бэрхийн уурхайн зүгээс Юден Такс Тин Аудит ХХК-аар хийлгэсэн шинжээчийн дүгнэлт, Итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолыг үндэслэн нийт төлөөллийн эрхтэй 88 иргэнд 2 удаа олгох 7 тэрбум 32 сая 820405 төгрөгийн нөхөн төлбөр олгох тооцоолол гаргуулсан байна.

2 дугаарт Хэнтий аймгийн Бэрхийн уурхай 1954 онд анх байгуулагдаж, 74 оноос Монголпросцветмет нэгдлийн бүрэлдэхүүнд орж, Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 74 дүгээр тогтоолоор Бэрх уул төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд Төрийн өмчийн хороо /хуучин нэрээрээ/ 2001 оны 442 дугаар тогтоолоор Бэрх уул төрийн өмчит үйлдвэрийн газрыг ХК болгон тус тус өөрчлөн байгуулагдсан байна.

Улмаар Засгийн газрын 2002 оны 9 дүгээр тогтоолоор баталсан төрийн өмчийн 2002 онд хувьчлах хөтөлбөрт заасны дагуу Төрийн өмчийн хороо тус компанийн хувьчлалыг зохион байгуулж, 2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Эрдэнэс менежмент багт шилжүүлэн өгч, худалдах, худалдан авах гэрээ байгуулан Бэрх уул төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааны 67 хувийн хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлэн, 2005 онд Монголын хөрөнгийн биржээр үлдэх 33 хувьд ноогдох хувьцааг нийтэд худалдсан байна.

Бэрхийн уурхайчдыг төлөөлөн Асар их хүч төвийн тэргүүн, иргэн Д.Алтангэрэлээс нэр бүхий уурхайчдад олгох 2 удаагийн нөхөн төлбөрт 47 сая 790 мянга, 4 тэрбум юм байна тийм ээ, 4 тэрбум 790 сая 480334 төгрөгийг Монгол Улсын Засгийн газраас гаргах асуудлаар удаа дараа өргөдөл гомдол гаргасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас үүрэг болгосны дагуу Төрийн өмчийн хорооны даргын 2010 оны 85 дахь тоот тушаалаар ажлын хэсэг байгуулсан байна. Мөн 2013 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Төрийн өмчийн хорооноос ажлын хэсэг байгуулж, ажилласан бөгөөд 2013 онд байгуулагдсан ажлын хэсгээс нийт 196 хүнд 4,5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгуулах асуудлыг Засгийн газарт тавьж, шийдвэрлүүлэх дүгнэлт гаргасан байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2015 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 5/ 28 58 тоот албан бичгээр нөхөн төлбөр олгох асуудлыг дэмжсэн байдаг хэдий ч тухайн үеийн Засгийн газар шийдээгүй байна.

Бэрхийн уурхайчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэл уурхайчдад олгох 2 удаагийн нөхөн төлбөрт 4513480334 төгрөгийг Засгийн газраас гаргуулах асуудлаар 2017 оноос Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхэд хандсан бөгөөд шүүхийн үйл ажиллагаанд Засгийн газар итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төлөөлөл оролцож байсан. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 04 04 дугаар шийдвэрээр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 570 дугаар магадлалаар Бэрхийн уурхайд ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан, нас барсан иргэдэд нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Дээрх шийдвэрийн дагуу Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар байгуулагдсан, улмаар 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөр А/79 дугаар тушаалаар тус ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын хэлтэс Бэрхийн уурхайд ажиллаж байсан нэхэмжлэгч нэр бүхий 112 иргэдэд олгох нөхөн төлбөрийг хэмжээг Монгол Улсын Засгийн газарт 2023 оны Итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай 238 дугаар тогтоолд заасан цалингийн итгэлцүүрийг ашиглан тооцоолоход 9450196866 төгрөг байна.

Ажлын хэсгийн дүгнэлт Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 3.1.1.1 дэх заалт, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 04 04 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн Нөхөн төлбөр олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн байна.

3.Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хандан Бэрхийн уурхайн нэр бүхий 112 уурхайчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэлээс ирүүлсэн уурхайчдад олгох нөхөн төлбөрийн талаарх өргөдлийн дагуу Өргөдлийн байнгын хорооноос 2025 оны 10 дугаар сарын 15-ны Улсын Их Хурлын 10, 11 872 дугаартай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандан мэдээлэл авах тухай албан бичиг хүргүүлсэн бөгөөд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хариу ирүүлсэн.

Байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Д.Ганмаа нарт өргөдлийг судлан, холбогдох санал танилцуулахаар хуваарилсан бөгөөд энэ хүрээнд Улсын Их Хурлын гишүүд 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр холбогдох талуудыг оролцуулан уулзалт зохион байгуулж, тодорхой тайлбар, мэдээллийг авсан. Тус өргөдлийг судлан үзээд холбогдох талуудын тайлбар мэдээлэл дээр үндэслэн өргөдөл гаргагчийн хүсэлтийг зарчмын хувьд дэмжиж байгаа тул дээрх саналуудыг танилцуулж байна.

1 дүгээрт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд уг асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Засгийн газрын хуралдааны дараалалд оруулахад дэмжлэг үзүүлэхэд анхаарах.

2-т Монгол Улсын Засгийн газраас шүүхийн шийдвэрийн биелэлтийг шуурхай хангаж, Монгол Улсын 2027 оны төсөвт тусгахад анхаарах талаар Өргөдлийн байнгын хорооноос албан бичиг хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Танилцуулгыг дуусгалаа.

**О.Номинчимэг:** Саналаа танилцуулсан Ганмаа гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сандагийн Бямбацогт сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, одоо Засгийн газрын хуралдаан яг ид явагдаж байгаа, асуудал танилцуулж байгаа учраас удахгүй боломжтой болохоор орж ирнэ. Тилеуханы Аубакир сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд ирсэн байна. Алимаа дарга Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ бодлогын газрын дарга Ренчиндорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Батжаргал, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дэлгэрмаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын ахлах шинжээч Хишигжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн хөдөлмөрийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Ууганбаатар, нэхэмжлэгчийн итгэмжилсэн төлөөлөгч Алтангэрэл нар оролцож байна.

Энд өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу өнөөдөр энэ асуудалтай холбоотойгоор, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өргөдөл гаргагчийн буюу энэ Бэрхийн уурхайчдын итгэмжилсэн төлөөлөгч Алтангэрэл уг хэлэх хүсэлт гаргасан байгаа. Тэгэхээр та яг энэ өргөдлийнхөө агуулгыг, асуудлыг нь, гол асуудлаа 10 минутад багтаагаад товч, тодорхой танилцуулна уу гэж урьж байна. 8 номерын микрофон өгье.



**Д.Алтангэрэл:** Сайн байцгаана уу? Би Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Алтангэрэл гэдэг иргэн байна. Бид өмнө нь энэ Өргөдлийн байнгын хорооны хуралдаанд 2025 оны 12 сарын 9-ний өдөр ороход юуны Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас өгсөн танилцуулга гээд танилцуулга танилцуулж байсан. Тэгээд тэр нь аль 2018 оны 01 сарын 31-ний Засгийн газрын хуралдаанд оруулсан ташаа буруу мэдээлэлтэй, тэгээд төөрөгдүүлсэн ийм баримт өгүүлсэн байсан. Энэ тухай би ажлын хэсэгт орсон Ганмаа гишүүн болон Далайн Батбаяр гишүүдэд, Номинчимэг дарга нарт маш их баярлаж байгаа энэ асуудлыг судалж үзээд, бүгдээрээ байлцаж байгаад, нотлох баримтын хүрээнд үнэлж, асуудалтай танилцсан.

Тэгээд би энэ тухай танилцуулгатай холбогдуулж хэдэн зүйл хэлье гэж бодож байгаа юм Их Хурлын гишүүддээ. Тэгээд өөрийнхөө энэ гомдол тайлбар гаргасан энэ 25 оны 12 сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга Номинчимэг болон гишүүдэд гээд би гомдол тайлбараа гаргасан байгаа. Энэ танилцуулгатай холбогдуулаад яагаад энэ танилцуулга ийм ташаа болоод байна вэ, энэ буруу ташаа мэдээллээс болоод бид маш их хохирч, чирэгдэж манай иргэд ингээд асуудалд их маш удаан хойрго хандаж, нэлээн иргэдийн маань ихэнхийг нь залхаасан.

Тэгээд хамгийн сүүлд шүүхэд бол 112 иргэд шүүхийн шийдвэрээр эцсийн байдлаар ингээд шүүхийн шийдвэр гаргууллаа. Энэ шүүхийн шийдвэрийн биелэлт хангагдахгүй 22 оны 5 сарын 26-наас хойш 22, 23, 24, 25 гээд 4 жил гаруй энэ асуудал шийдэгдэхгүй өдий болтол яваад, сая Засгийн газрын хуралдаанд халти ормоор аядаад, тэгээд Засгийн газрын хуралдаанд орох яамнуудын санал дутуу байна гэдгээр алх тогшиж, Занданшатар гишүүн манай юуг асуудлыг хойшлуулсан гэж ойлгуулсан надад, тайлбарласан. Тэгээд одоо энэ гомдол ер нь аягүй энэ төрийн албан хаагчдын энэ буруу тайлбар, мэдээллээс болоод иргэд маш их хохирдог юм байна. Ер нь та нар энэ би нотлох баримтын хүрээнд 22 хуудас энэ баримтуудыг өгсөн байгаа.

Жишээлбэл энэ 2018 оны 01 сарын 31-нд баригдсанд гэр бүл юу, хөдөлмөр, нийгэм, тухайн үеийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас өгсөн танилцуулгад Бэрхийн уурхайг татан буугдсан, дампуурсан, хариуцагчгүй болсон гэдэг байдлаар ярьсан, юу танилцуулгад дурдсан. Тэгээд энэ бол ерөөсөө тийм юм байхгүй. Юу гэхлээр дампуурсан бол Дампуурлын хуулийн дагуу шүүхийн шийдвэр гаргах ёстой, тэр баримт, нотлох баримт нь хангагдаагүй. Татан буугдсан бол татан буугдсан тухай эрх зүйн акт баримт бичгүүд байх ёстой, тэр бас хангагдаагүй. Тэгээд хариуцагчгүй болсон гэж байгаа юм. Ер нь тэгээд тухайн үеийн энэ манай Бэрхийн уурхайчдын яг энэ асуудал бол юу гэхээр тэр менежментийн хувьчлалаар хувьчлагдсан биш, өнөөдөр юугаар 2004 оны 6 сарын 01 хүртэлх төрийн өмчийн үйлдвэрийн газар буюу Төрийн өмчийн хорооны харьяанд байх хугацааны энэ юунууд байгаа асуудал байж байгаа. Нөхөн төлбөртэй холбоотой Хөдөлмөрийн тухай хуулийн 99 он, 1999 оны 97 дугаар зүйлийн нэгд холбогдуулан гаргасан.

Энэ дээр бол та нарт өгсөн баримт дээр тодорхой дурдсан байгаа Засгийн газрын 74 дүгээр тогтоол 99 оны, энэ дээр уг тогтоолоор Бэрхийн уурхайг төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулаад, тэгээд 74.3Г заалтад бүүр тодорхой дурдсан. Бэрхийн уурхайд ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвдсөн нэр бүхий нэг зуун, 286 иргэдийн асуудлыг урьд өмнө нь мөрдөж байсан журмын дагуу Монголросцветмет нэгдэлд нийгмийн хамгааллын асуудлыг хариуцуулахаар ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг ингээд Төрийн өмчийн хорооны



дарга Зоригтод даалгасан байдаг юм Засгийн газар заалтаар. Тэгээд энийг хэрэгжүүлэлгүй Төрийн өмчийн хороо орхигдуулсан гэж бид ярьдаг. Төрийн өмчийн хороо бол тухайн үед 4 мянган төгрөгийн нөхөн олговор олгосныгоо нөхөн төлбөр өгсөн гэж ярьдаг. Тэгээд шүүх дээр энэ асуудал нь хэлэлцэгдээд эс үйлдэхүй гэдгийг хүлээн зөвшөөрч шүүхийн шийдвэр гарсан. Тэгээд энэ баримтуудыг та бүгдэд хавсаргасан байгаа.

Дээр нь Сугар даргаас 2008 оны 4 сарын 22-ны 1А/ 850 албан бичгийг эд нар дурддаг, тэрний дэмжээгүй гэсэн агуулгаар дурддаг. Гэтэл тэр бичгийн эцэс дээр нь би энэ бичгийг та бүгдэд өгсөн байгаа. 2004 оноос өмнөх асуудал байвал хамтарч энэ Бэрхийн уурхайчдын асуудлыг харилцан шийдвэрлэлцэж ярилцахад бэлэн байна гэсэн агуулга бүхий ийм албан бичиг байгаа. Энийг бол нөгөө албан юугаа дагалдуулаад өгсөн. Нотлох баримтын хүрээнд үнэлүүлэхээр та бүгдэд өгсөн.

Мөн 3 дахь дээр нь Монголросцветмет нэгдэл хоёр мянга, нэгдлийн 2010 оны 9 сарын 29-ний өдрийн 1/19 75 гэсэн албан бичигт юу гэж дурдсан бэ гэхлээр 2001 он, 2007 онд Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1-ийг хэрэгжүүлсэн 2 удаа нөхөн төлбөр олгосон, ингэхдээ Бэрхийн уурхайг бол хамруулаагүй, огт хамруулаагүй гэдгийг, энэ 2 удаагийн нөхөн төлбөртөө огт хамруулаагүй гэдгээ илэрхийлсэн энэ агуулга бүхий баримт бичиг байгаа. Тэгээд тухайн үед Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Төгсжаргалын Гандигийн нөгөө албан бичиг Төрийн өмчийн хорооны дарга Сугарт 2010 оны 3 сарын 5-ны өдрийн 1/525 тоот албан бичгийг хавсаргасан байдаг юм, хүргүүлсэн байдаг. Энэ агуулга, энэ албан бичгийн гол агуулга нь юу вэ гэхлээр 2003 оны Засгийн газрын 65 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлж, энэ Бэрхийн уурхайчдын нөхөн төлбөрийн асуудлыг шийдэх ёстой гээд, би одоо бас л аягүй энэ нотлох баримтаар та бүгдэд хавсаргасан байгаа.

2003 оны 3 сарын 19-ний өдрийн 65 дугаар тогтоолын 2-т төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагыг хувьчлахдаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байх хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн чадваргүй болсон иргэдэд хөдөлмөр хууль, Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу олгогдох нөхөн төлбөрийн асуудлыг хамтад нь шийдвэрлэж байхыг Төрийн өмчийн хорооны тухайн үеийн дарга Пүрэвдоржид үүрэг болгосон энэ Засгийн газрын тогтоол байдаг. Гэтэл энэ 2003 оны энэ 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх биш, харин Гэр бүл, хөдөлмөр, нийгэм, тухайн үеийн Гэр бүл, хөдөлмөр, нийгэм, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэргэжилтнүүд болохоор 2003 оны 65 дугаар тогтоолын нэгээр ингээд хариуцагчгүй, татан буугдсан, дампуурсан гэдгээр 97.4-өөр нөхөн олговор олгосон байдаг.

Тэгээд энэ асуудал дараа нь 2007 оны сайдын 12, 17 тоот тушаал байдаг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаал энэ нөхөн төлбөр олгох нь зүйтэй гэсэн үндэслэлтэйгээр тушаалын гол агуулга нь. Тэгээд 2007 оны 02 сарын 16-ны 3/318-д энэ Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын нөхөн төлбөр олгох ажлыг зохион байгуулах тухай гэсэн ийм зөвлөмж байдаг. Тухайн зөвлөмж дээр юу гэж байдаг вэ гэхлээр нэг хүнд 200 мянган төгрөгөөр тооцож нөхөн олговрыг олго гэсэн агуулга бүхий байдаг.

Тэгээд ажлын хэсэг дээр энэ Дорнод аймгаас Бэрх уулаас, Хэнтий аймгаас ирсэн бичгүүд, Сүхбаатар дүүргээс ирсэн бичгүүдэд Улаанбаатарт байгаа улсуудад ижил нөхцөлтэй улсуудад 145 мянган төгрөгийн нөхөн олговор, Дорнод аймагт байгаа иргэдэд 240 мянган төгрөгийн нөхөн олговор, Бэрхийн уурхайд байгаа

хүмүүст 100559 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон байдаг юм. Тэгээд энэ ажлын хэсэг дээрээ Төрийн өмчийн хорооны хуралдаанд ярилцаад энэ ч ижил нөхцөлтэй улсууд яагаад ийм өөр өөрөөр олгож байгаа юм, тэгш эрхийн зарчим хаана байна вэ, тэгш эрхийн зарчим алдагдсан байна гээд 37 тоот тэмдэглэл гаргасан Төрийн өмчийн хорооны хуралдааны.

Тэгээд уг тэмдэглэлд юу гэж дурдсан бэ гэхлээр 2011 оны 11 сарын 3-ны өдрийн 37 тооттой Төрийн өмчийн хорооны хуралдааны тэмдэглэлээс, хэлэлцсэн асуудал нь Бэрхийн уурхайд ажиллаж байсан уурхайчдад олгох нөхөн төлбөрийн асуудалд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт. Тэмдэглэсэн нь Бэрхийн уурхайд ажиллаж байсан, ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас группт орсон бол нас барсан уурхайчдын ар гэрт олгох нөхөн төлбөр хууль зүйн үндэслэл байгаа эсэх, хууль зүйн үндэслэл байгаа бол уг мөнгийг ямар байгууллага олгох талаар хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг сонслоо гэж байгаа юм. Тэгээд шийдвэрлэхдээ юу гэж шийдвэрлээд энэ 37 тоот тэмдэглэл дээр үүрэг өгсөн бэ гэхлээр Төрийн өмчийн хорооны даргын, юу 2010 оны 85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажлаа үргэлжлүүлэн Бэрх уул, юуны 5 сар, Бэрхийн уурхайд 2004 оны 5 сар хүртэл хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болсон, нас барсан иргэдийн ажилтны нэрсийн жагсаалтыг гарган, жагсаалтад орсон хүмүүст Хөдөлмөрийн тухай хуулийн 97-гийн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Баярлалаа. Дэгийн дагуу 10 минут байгаа учраас Алтангэрэл итгэмжилсэн төлөөлөгчид баярлалаа. Өнөөдөр энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Баасанжаргал гишүүнээр тасалъя. Баасанжаргал, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүний микрофон.

**Х.Баасанжаргал:** Юуны өмнө 112 иргэнийг төлөөлөөд энэ урт удаан хугацааг туулсан Алтангэрэл танд баярлаж, талархаж байгаагаа илэрхийлье. Энэ бол тийм амар зүйл бол биш. Тэгээд хамгийн харамсалтай нь манай төр өөрөө шүүхийн шийдвэр гарчхаад байхад шүүхийн шийдвэрээ биелүүлэхгүй энэ олон жилийг өнгөрөөнө гэдэг өөрөө аягүй харамсалтай зүйл. Манай Өргөдлийн байнгын хороон дээр бас яг нэг иймэрхүү агуулгатай өргөдлүүд бол маш их ирж байгаа. Тэгээд төр өөрөө шүүхийн шийдвэрээ биелүүлэхгүй байхаар иргэдээс бид үүнийг хүснэ гэдэг бол өөрөө их сонин асуудал шүү дээ. Тэгэхээр энэ дээр яам, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам одоо энэ холбогдох ажлын хэсгийн гишүүд нь ирчихсэн байгаа гэж ойлгож байгаа, зөв тийм ээ? Ажлын, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан хариу хэлэх байх.

Энэ бичгийг аваад ингээд хоорондоо ингэж явахад энэ олон жил өнгөрөөх ямар хугацаа, ямар хэрэгцээ шаардлага байсан юм бэ? Энэ олон хүмүүсийн энэ хохирлын асуудлыг энэ олон жил явж байж шүүхдэж байж, арайхийж ингэж шүүхийн шийдвэр нь гарчхаад байхад энэ асуудлыг нь шийдэхгүй яагаад ингэж удаад байдаг юм бэ? Хууль нь болохгүй байгаа юм уу, эсвэл хоорондын ажлын уялдаа нь болохгүй байгаа юм уу, мөнгө нь байхгүй байгаад байгаа юм уу, яг хаанаа, ямар асуудал байгаа гэдэг дээр маш тодорхой тайлбар хэлэхийг хүсье?

2 дугаарт манай Байнгын хорооноос нөгөө хяналт шалгалтын цаглавар гэж гарах ёстой. Тэгэхээр яг энэ хүрээнд ялангуяа энэ нөгөө захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл бол маш муу байгаа. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл муу гэдэг нь хариуцагч нь дандаа төр байгаа гэсэн үг. Төрийн

байгууллага ерөөсөө шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа л гэсэн үг шүү дээ захиргааны хэргийн. Тэгэхээр энэ дээр бас яг тусгайлан хяналт шалгалтын цаглавартаа бас би бол оруулах саналтай байна. Яагаад ингээд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт маш муу байгаад байдаг юм бэ, хаанаа ямар асуудал байгаад байдаг юм бэ, төр нь яахаараа шүүхийн шийдвэрээ биелүүлдэггүй юм бэ гэдгийг бол асуудал болгож ирж, манай Өргөдлийн байнгын хороо дараагийн жилийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд оруулаад, энийг бүүр тусгайлан хяналт шалгалтынхаа цаглаварт оруулах гэсэн ийм саналтай байгаад байна. Тэгээд энэ дээр холбогдох яамныхан тайлбар, маш тодорхой тайлбар хэлээрэй гэж хүсье. Тэгээд би өмнө нь байгаагүй, энэ ажлыг шинэ авсан, эсвэл манай ажлын хэсэг шинээр байгуулагдсан гэдгийг бол би ерөөсөө тайлбар гэж бид хүлээж авахгүй шүү.

**О.Номинчимэг:** Цаглавартай холбоотой саналыг хүлээж авлаа. Бид хаврын чуулганаар нэлээн хууль тогтоомжийн хэрэгжилт рүү анхаарсан хяналт шалгалтын ажиллагааг Өргөдлийн байнгын хороон дээр хийхээр төлөвлөж байна. Ер нь бид олон зуун хууль батлаад л байдаг, батлаад л байдаг. Яг хэрэгжилт нь, үр нөлөө нь хаана, яаж гарч байгаа юм бэ гэдэг дээр үнэхээр бид ч, иргэд ч хэлж байгаа асуудлууд байгаа. Тэгээд хэчнээн сайхан цагаан дээр хараар бичсэн хууль гаргаад хэрэгжихгүй байвал бидний үйл ажиллагааны тэгвэл үр өгөөж хаана байгаа юм бэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр Өргөдлийн байнгын хороо бол ер нь хаврын чуулганаар хууль тогтоомжийн хэрэгжилт рүү хэрэгжилтийг хангах чиглэл рүү үйл ажиллагаагаа голчилж явуулна, байнгын ажиллагаатай Байнгын хорооны хувьд. Ялангуяа иргэдэд чиглэсэн энэ хууль тогтоомжууд хэрхэн яаж хэрэгжиж байна гэдэг дээр нэлээн далайцтай ажлууд хийнэ гэдгийг хэлмээр байна. Ингээд эхлээд эхний Баасанжаргал гишүүний асуултад хэн хариулах вэ? Яагаад энэ асуудал удаад, 2022 онд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бол гаргаад эцэслэгдчихсэн юм байна шүү дээ. Тэгээд яагаад одоо чинь 3 жил болсон уу, 3 жил болоогүй юм бэ гэдэг асуудал. 2 номерын микрофон. Та нэрээ хэлээд, гишүүний асуултад хариулна уу?

**Д.Ренчиндорж:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар ажилладаг Ренчиндорж хариулж байна. Шүүхийн шийдвэр хамгийн сүүлд 22 оны 10 сард Дээд шүүхээс гомдлыг хүлээн авахаас татгалзсанаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал бол хуулийн хүчин төгөлдөр болсон. Хуулийн хүчин төгөлдөр болсон хугацаанаас хойш шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр ажлын хэсгүүд байгуулж, Засгийн газар хариуцагчаар оролцож ажилласан учраас холбогдох Засгийн газрын шийдвэрийг гаргуулахаар саналуудаа бол Засгийн газрын гишүүдээс санал авч, хувилбаруудыг бол танилцуулсан байдаг.

Үндсэндээ бол шийдвэр яагаад өнөөдрийг хүртэл биелэгдэхгүй байгаа юм бэ гэхээр энэ нөхөн төлбөрийг олгох төсөв батлагдаагүй, нөөц сангаас гаргуулъя гэдэг байдлаар хамгийн эхний тогтоолын төсөл бол явсан. Хууль зүйн сайд болон Сангийн сайдаас энэ тухайн асуудлыг бол улсын төсөвт тусгах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй байна. Сангийн нөөц сангаас бол гарах боломжгүй гэсэн учраас Засгийн газраар эхний удаа хэлэлцэх боломжгүй болоод буцсан. Дараагийнх нь бол Үйлдвэрлэлийн ослын сангаас гаргах боломжууд байна уу, дараа жилийнх нь төсөвт суулгах байдлаар шийдвэрлэх боломжтой юу гэдэг саналыг бас танилцуулсан. Мөн энэ сан дээр тусгайлсан төсвийг батлахгүй бол боломжгүй байсан учраас мөн шийдвэрлэх боломжгүй гээд хэлэлцэж чадаагүй. Хамгийн сүүлийн байдлаар 27 он, 26, 27 оны төсөвт улсын төсөвт тусгайлан энэ мөнгийг суулгаж байж эх үүсвэрийг шийдвэрлэж байж олгох байдлаар Засгийн газарт

танилцуулга материал, тогтоолын төсөл бол хүргэгдчихсэн ийм байдалтай байгаа. Хариулж дууслаа.

**О.Номинчимэг:** Яах вэ юу л байна, би зүгээр сая энэ хэргийг Ганмаа гишүүний танилцуулгыг, Алтангэрэл итгэмжилсэн төлөөлөгчийн танилцуулгыг, энэ хэрэг дээр чинь 9 сард өргөдөл ирсэн байна. 2, 3 сар орчим 2 гишүүн маань ажилласан, асуудлуудыг нь манай ажлын алба, Байнгын хорооны ажлын албаныхан ажилласан. Зүгээр энэ та бүхний гэхээсээ илүү ер нь энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоог бид харахгүй бол болохгүй байна. Энэ чинь 2, 3 жилийн өмнө л Дээд шүүхийн шийдвэр гарчхаад байгаа шүү дээ. Тэгээд яг шийдье гээд тэгэхээр нөөц сан байх ёстой, төсөвт суух ёстой гээд жилээс жил рүү шилжигдээд яваад байгаа асуудал нь ер нь хэр зохимжтой юм.

Яагаад гэвэл Улсын Их Хуралд бол энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай шинэчилсэн хууль нь бол өргөн баригдчихсан, бас л хэлэлцэж чадахгүй ингээд яваад байдаг. Тэгээд нэг хүний эрх, эрх зөрчигдлөө, шударга ёс тогтоолоо гэдгийн хамгийн эцсийн цэг нь шүүх шийдвэр гаргаад дуусчихдаггүй, шүүхийн шийдвэр нь биелж байж энэ чинь яг бодит үр дүнгээ олдог. Тэгтэл яг өнөөгийн нөхцөл байдалд бол иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл 20-оос 30 хувьтай 2024 оны байдлаар, мөнгөн дүнгийнх бол 31 хувь нь л биелсэн, маш хангалтгүй. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хувьд ч гэсэн 2018 оноос байнга шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тоо хэмжээ тогтмол буурч ирж байгаа. 23 онд бол нийт 26 тэрбум төгрөгийн гүйцэтгэх хуудаснаас 19,5 тэрбум нь төлөгдсөн, 6 тэрбум гаруй нь үлдэгдэлтэй байна л гэсэн ийм тоо гараад байгаа юм.

Тэгээд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл зөвхөн мөнгөтэй холбоотой биш, бас даалгасан шийдвэр, шийдвэрүүд их гардаг. Энэний хувь хэмжээ бол маш муу юм байна лээ. Тэгэхээр энийг шүүхийн шийдвэр Дээд шүүх бид чинь гуравдагч засаглал, Дээд шүүх маань шийдвэр гаргалаа л бол, эцэслэгдлээ л бол энэ чинь биелдэг байх ёстой хууль дээдлэх ёс байдаг юм уу тийм тогтолцоотой шүү дээ. Тэгэхэд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь явдаггүй, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь явдаггүй, эрүүгийнх бол яваад байх шиг байгаа юм. Төрийн захиргааны энэ хэм хэмжээ бол нэлээн сайн яваад байх шиг байгаа юм. Энэ хоёроо алдчихаад байгаа нь өөрөө иргэдийн дунд ч гэсэн нөгөө шударга ёс чинь хаана байна, олон жилийн дараа бид хохирлоо нөхөн төлүүлэх гэхээр байхгүй, дахиад шүүх дээрээ олон жил болно. Шүүхийн шийдвэр дээр очоод дахиад одоо энэ хэрэг бол 3 жил болж байгаа юм байна, 10 жил болж байгаа ч асуудал байна.

Тэгээд манай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд чинь шүүхийн шийдвэр гарснаас хойш хүү тоолдог, хүү тооцдог ийм систем байхгүй. Тэгэхээр яадаг юм өнөөдөр би 5 тэрбум төгрөгийн шүүхийн шийдвэр гаргачхаад өнөөдөр төлөхгүй, 5 жилийн дараа төлөх нь инфляцдаа идэгдээд, мөнгөний үнэ цэн идэгдээд, үнэ цэнгүй болно. Ямар ч төлөх incentive байхгүй. Энэ чинь өөрөө бүхлээр нь харвал иргэдийн хувьд ч гэсэн хохирч байгаа, бизнесүүдийн хувьд ч гэсэн нөгөө бизнес эрхлэх таатай орчин, тогтвортой байх, тодорхой хууль, эрх зүй тодорхой байх, тооцоолол эрсдэлийн юманд нь бүгдэд нь нөлөөлөөд маш том гажуудлыг бол үүсгэхээд байгаа. Энийг нь бид уг нь Улсын Их Хурал дээр ороод ирчихсэн байгаа хуулийг явуулчихмаар байгаа юм, удаад байхгүй. Энэ чинь хаврын чуулганаар өргөн баригдсан хууль.

Тэгээд энэ кейсийн хувьд ч гэсэн 22 оны шүүхийн шийдвэр шүү дээ, 22 онд Засгийн газрын бүтэц ямар байсан юм, одоогийн мэдээж хүмүүс зарим нь байсан байх, зарим нь байгаагүй байх. Гэхдээ яагаад ингээд төсөвт суулгаж байж, нөөц сангаас гэдэг олон нөгөө нэг ийм процессын юмнуудаас болоод хойшлоод байгаа нь бол иргэдийн зүгээс харахад ойлгомжгүй байхгүй юу. Төр шүүхийн шийдвэр гаргалаа бол тэрийгээ биелүүлдэг л байх хэрэгтэй байгаад байна. Тэгээд энэ дээр бол яах вэ өнөөдөр энэ чинь манай Ардчилсан намынхан маань бүлгийн хурал гээд бүгдээрээ гараад явчихсан байна уу тийм ээ, бүлгийн хурал зарлагдсан байна гээд. Гишүүд маань хууль өргөн барьж байна, өргөн барьсан гишүүд маань ороод ирлээ. Бүгдээрээ ерөнхийдөө нэг үзэл санаа, байр суурьтай байгаа гэж бодож байна.

Энэ бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудал биш, энэ бол угаасаа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал. Тэгээд энэ дээр бол Байнгын хорооноос бид Засгийн газар луу Ганмаа гишүүн, Далайн Батбаяр гишүүн нарын гаргасан санал дээр үндэслээд бичиг явуулж, энэ асуудлыг түргэвчлүүлэх дээр анхааръя. Үнийн дүнгийн хувьд бол шүүхийн шийдвэр нь бол үнийн дүн нь бол яг тийм аймаар үнэтэй бол биш л харагдаад байх юм. Тэгээд яагаад нэг энэ хэдэн иргэдийнхээ асуудлыг шүүхийн шийдвэрээ гүйцэтгэхгүй байгаа дээр бол, энийг бол яамныхан бол их ойлгоод байгаа гэж би хараад байгаа шүү дээ. Уг нь хөөцөлдөөд, шийдүүлэх гээд яваад байгаа, сайдаас ирсэн бичиг дээр ч гэсэн бүх тооцооллыг шинэчилж гаргаад ингээд ажиллаж байна л гэдэг хариу өгч байгаа. Тэгэхээр энэ дээр одоо энэ хүчин чармайлт, яамны хүчин чармайлт маань яг үр дүн болох асуудал дээр л цөмөөрөө анхаарах ёстой юм байна.

Тэгээд энэ дээр бол нэг их аймаар зарчмын бүүр их маргалдаад байгаа асуудал бол нэг их байхгүй гэж ойлгоод байгаа шүү дээ, зөв үү? Зөрчилдөөд байгаа асуудал байгаа юу? Би нэг асуулт асуучихъя. Энэ дээр зарчмын ёстой зөрчилдөөд, энэ асуудал дээрээсээ л болоод санал нийлэхгүй энэ шийдэгдэхгүй байгаа гэдэг асуудал байгаа юм уу? Хэн харуулах вэ? 3 номерын микрофон, Алимаа дарга.

**Б.Алимаа:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Алимаа хариулж байна. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Ямар нэгэн зөрчилдөх асуудал бол одоогийн түвшинд бол байхгүй. Бид Засгийн газрын хуралд оруулах материалууд бэлдээд, яамдаас санал аваад, ингээд эцэслэн шийдвэрлэх байдлаар бол явж байгаа. Энэ дотор бол улсын төсвөөс гаргуулах нь зүйтэй гэдэг байр суурин дээр бол яамнууд тогтсон байгаа. Тэгээд Засгийн газрын тогтоолын төслийг яг энэ агуулгаар боловсруулаад, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байж байгаа. Тэгээд энэ агуулгаар батлагдах байх гэж ингэж найдаж байгаа. Өөр зөрчилдөх асуудал бол байхгүй.

**О.Номинчимэг:** Түрүүн асуулт асууж, үг хэлэх хүмүүс нэрээ өгөөд дуусчихсан байсан. Ингээд ерөнхийдөө бол зөрчилдөх асуудал байхгүй байгаа гэж ойлголоо. Энэ зүгээр манлайллын асуудал байгаа байх, 22 оны асуудал. Тэгэхээр энэ дээр бол 2 гишүүнийхээ гаргасан санал дээр үндэслээд, бид Байнгын хорооноос энийг түргэвчилж шийдэх асуудал дээр анхаарч, Засгийн газарт Өргөдлийн байнгын хорооноос бичиг явуулъя гэж бодож байна. Нэг дэх асуудал дууслаа, асуудлыг хэлэлцэж дууслаа. Хүрэлцэн ирсэн ажлын хэсэг болон өргөдөл гаргагчид баярлалаа.

14.33 цаг

*Хоёр.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэх*



Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн 2 дахь асуудал бол иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хэлэлцэх байгаа. Энэ иргэн, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл гомдлууд бол иргэдийн өөрийнх нь хувийн мэдээлэл, хүний хувийн нууц агуулсан өргөдөл гомдлууд байгаа. Тэгээд өмнөх бас Байнгын хорооны хуралдааны жишгийн дагуу энэ Байнгын хороог яг энэ хувийн өргөдөл хэлэлцэх асуудал дээр бол хаалттай горимоор явуулах шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ бол өөрөө хуулийн биелэлтийг хангах үүднээс. Ингээд Байнгын хороог хувийн, хүний хувийн мэдээлэлтэй холбоотой өргөдлүүдийг хэлэлцэж байгаа учраас хаалттай явуулъя, горимоор явуулах шаардлагатай гэж үзэж байгаа учраас горимын санал гаргаж байна. Гишүүд санал хураалтад бэлдье горимын санал дээр. Горимын санал дээр Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн санал байна гэж байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний микрофон өгье.

**С.Эрдэнэбат:** Энэ өргөдлүүдтэй танилцсан. Тэгэхдээ яах вэ би нэг түрүүн үг хэлэх гээд байгаа нэг шалтгаан нь саяын тэр осол аваарт өртсөн гээд одоогоор 20 жилийн өмнөх хүртэл ингээд ийм асуудлууд байгаа, ийм асуудал зөндөө байгаа юм. Тэгэхээр би яах вэ цаашдаа яах вэ яг ийм асуудал дээр хувь хүний өргөдөл гэхээсээ илүүтэй зарим нь төлөөлөөд ярьсан, мөн нийтээр ярьж болохуйц яг тухайлсан хувь хүний нууц гэхээсээ илүүтэйгээр ийм хүмүүсийн асуудлыг цаашаа дандаа хаалттай хийгээд явах юм уу? Уул нь бол нээлттэй байвал магадгүй Өргөдлийн байнгын хорооноос энэ өргөдлийг шийдсэн жишгийг хараад бусад төрийн байгууллагууд болон энэ иргэдийг хохироогоод байгаа, чирэгдүүлээд байгаа хүмүүс дор дороо асуудлаа шийдэхэд нь би нэмэртэй болов уу гэдэг үүднээс зарим нийтлэг иргэдэд тохиолдож байгаа ийм асуудлуудыг нээлттэй байдлаар явуулаад, яг энэ дотор бол бүр тухайлан хувь хүний нууцтай холбоотой юмыг нь ялгаж салгаж тавихгүй бол цаашдаа бид хувь хүн болгоны асуудлыг бүгдийг нь нууж байгаад хурал хийхээр процессын хувьд, цаашдаа бас нийгэмд өгөх мессеж болон төрийн байгууллагад өгөх үүднээс энэ зарим асуудлуудыг нь, ялангуяа манай хороо маань шинээр байгуулагдаж байгаа хороо учраас жишиг тогтчихвол урьд нь шийдсэн хэргүүд гэдэг байдлаараа олон хүн хандахгүйгээр ингээд төрийн байгууллагууд ч гэсэн хараад явчих болов уу гэж бодож байна.

Би тэгээд сая ч гэсэн энэ Хөдөлмөрийн яамныхан уул нь өөрсдөө шийдчих ёстой асуудлыг тэгээд заавал шүүхийн шийдвэр, Засгийн газар, Их Хурал руу оруулж ирж байгаад шийдүүлэх гээд байгаа нь бол би бол зарим талаар бол ажлаа хийхгүй байна гэж харж байгаа юм. Энэ мэт саяын үйлдвэрлэлийн осолд өртсөн шиг маш олон хүмүүс байгаа байхгүй юу. Тэгээд энийг л хэлэх гээд байсан учраас яах вэ цаашдаа би одоо бол саналаа хураагаад явчихъя гэж бодож байна. Цаашдаа энийг ангилаад хэдүүлээ жишиг болохуйц, нэрийг нь дурдахгүй байж болно шүү дээ тийм үү, ийм байдлаар ингээд явчхаж байвал манай Байнгын хорооны олон иргэн нөгөө хандаж байгаа асуудлууд маань арай процессын хувьд болон үйл ажиллагааны хувьд жишиг болоод явчих юм болов уу л гэж бодож байна. Тийм, баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Эрдэнэбат гишүүнтэй санал нэг байна. Тэгээд яг таны хэлж байгаа жишгийн дагуу бид нийтийг хамарсан энэ асуудлуудаа ил нээлттэй хэлэлцэж байгаа. Яалт ч үгүй одоо хэлэлцэх асуудлууд болохоор хүний эмзэг мэдээлэлтэй, гэмт хэргийн факт, хүний эрхийн асуудалтай холбоотой гээд нэлээн эмзэг асуудлуудтай холбоотой хэргүүд байгаа учраас хаалттай байгаа. Мэдээж энэ асуудлууд дээр хэлэлцээд, энийг бол ил тод биш, хэрвээ өргөдөл гаргагч маань өөрөө энэ дээр нээлттэй оролцоход татгалзах зүйлгүй гэвэл бид



өргөдөл гаргагчаа оролцуулаад, холбогдох байгууллагуудыг оролцоод нээлттэй энийг хэлэлцэх боломжтой байгаа.

Өнөөдрийн энэ бидний одоо хэлэлцэх гэж байгаа асуудал бол дандаа хувь хүнтэй холбоотой, тэр хүмүүсийн хувийн асуудлууд болон хүний эрхтэй, гэмт хэрэг үйлдсэн, үйлдээгүй, ялтай холбоотой гэх мэтчилэн асуудлууд байгаа учраас энийгээ бид хуулийн дагуу хаалттай хэлэлцэхээр болж байгаа гэдгийг хэлмээр байна. Ингээд горимын санал санал хураая. Санал хураалтдаа бэлдээрэй. Ингээд хувь хүний өргөдлүүд, хүний хувийн мэдээлэлтэй холбоотой өргөдлүүд байгаа тул Байнгын хорооны энэ 2 дахь асуудлыг хаалттай горимоор явуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураая. Горимын санал дэмжигдсэн тул, 66,7 хувиар дэмжигдсэн тул горимын Тамгын газар хаалттай хуралдааны бэлтгэл хангана, 5-аас 10 минут болно.

Ер нь яах вэ бид энэ асуудлыг Даргын зөвлөл дээр тавьж, энэ хаалттай хуралдааны дэг маань хуулийн дагуу нэлээн тийм нүсэр процесстой. Бидний хувьд бол энэ төрийн нууц гэхээсээ илүү хувь хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудал байгаа учраас өөр бас нэг ийм журамтай болох асуудлыг бол бид ярилцах ёстой байгаа. Иргэдийнхээ асуудлуудыг түргэн шуурхай, ажил хэрэгчээр хэлэлцээд явах асуудал дээр. Ингээд хаалттай хуралдааны бэлтгэлийг Тамгын газраас хангая.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА